



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/382

Улаанбаатар хот

“Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэгийн”  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,715,112 (гурван сая долоон зуун арван таван мянга нэг зуун арван хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг (Ч.Янжиндулам)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 9 нэр төрлийн нийт 3,715,112 (гурван сая долоон зуун арван таван мянга нэг зуун арван хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгахыг Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг (Ч.Янжиндулам)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001059

